ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ЗАА-2026/089/НА-СТА-ТШЗ**

---


Дарга,
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар
Утас: 99105506 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Жалбаа
Утас: 89330330 Цахим хаяг: jalbaab@audit.gov.mn


---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2026.02.25 № 190

АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
С.БОЛДБААТАР-Т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орон нутгийн төсвөөс Улс төрийн намуудад 103.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, 9.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нарын үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах гадаад, дотоодын сургалтын арга хэмжээнд 444.4 сая төгрөгийг зарцуулж, 114.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж /таблет/ бэлтгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь батлагдсан төсвийг үр ашиггүй үрэлгэн, зориулалт бус зарцуулсан, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг хэмжээг баримтлан ажиллаагүй, төлөөлөгчдийг чадавхжуулах ажлын хүрээнд хийгдсэн гадаад улсад туршлага судлах ажлыг сургалтын байгууллагатай хамтран хэрэгжүүлээгүй, хуулийн этгээдийн дансанд байршуулж зарцуулснаар тайлагнасан, аливаа хуулийн этгээдтэй гэрээ байгуулан ажил гүйцэтгүүлэхдээ үйл ажиллагааны чиглэлийг харгалзан үзээгүй, өмнөх аудитаар илэрсэн орон тооны зөвлөх ажиллуулж цалин урамшуулал олгосон зөрчлийг давтан гаргасан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлын албаны бүтэц, орон тоо, ажиллах журмыг холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрээр батлаагүй мөртөө хоёр ажилтан томилж төрийн үйлчилгээний албан хаагчаар цалинжуулсан, албан хаагчдад үр дүнгийн урамшууллаас гадна нэмэлт

D:\Албан бичиг\A4-2026.docx

0260541

урамшуулал, шагнал олгосон, спорт заалны түрээс болон фитнесийн сургалтын төлбөр төлсөн зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-д "Зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар, Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Зохицуулах зөвлөлөөс баталсан нийтлэг журамд нийцүүлэн батална", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-д "Засгийн газрын агентлагийн дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны этгээд ажиллуулахыг хориглоно", 12 дугаар зүйлийн 12.1.4-д "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолоор баталсан "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам"-ын 3.5-д "Төлөөлөгчийг чадавхжуулах арга хэмжээг Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага болон холбогдох сургалтын чиглэлээр мэргэшсэн сургалтын бусад байгууллага, судлаачдын багтай хамтран зохион байгуулна", тус журмын хавсралтаар баталсан зардлын жишиг, Засгийн газрын 2020 оны 107 дугаар тушаалаар баталсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журам"-ын 6.2-д "Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Зохицуулах зөвлөлөөс баталсан нийтлэг журамд нийцүүлэн батална", 6.3-д "Аймаг, нийслэл, дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл нь орон тооны нарийн бичгийн даргатай байх бөгөөд нарийн бичгийн дарга нь төрийн захиргааны албан хаагч байна" гэж заасан заалтуудтай нийцэхгүй, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс нэгтгэсэн санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-ЭНДРАА

**Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **25,572,943.00** | **7,168,900.00** |
| **33** | **АВЛАГА** | 20,587,043.00 | 00.00 |
| **335** | **Бусад авлага** | 20,587,043.00 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 20,587,043.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 4,985,900.00 | 7,168,900.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 4,985,900.00 | 7,168,900.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 4,985,900.00 | 7,168,900.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **80,904,073.77** | **210,454,279.38** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 80,904,073.77 | 210,454,279.38 |
| **392** | **Биет хөрөнгө** | 80,904,073.77 | 210,454,279.38 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 74,000,000.00 | 74,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -24,666,666.72 | -49,333,333.44 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 68,164,326.00 | 206,475,169.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -40,095,444.19 | -71,082,100.66 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 19,935,385.00 | 64,458,361.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -16,433,526.32 | -14,063,816.52 |
| 39301 | Програм хангамж | 480,000.00 | 480,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -480,000.00 | -480,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **106,477,016.77** | **217,623,179.38** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **6,695,000.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 6,695,000.00 |
| **413** | **Өглөг** | 00.00 | 6,695,000.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 00.00 | 6,695,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00.00 | 6,695,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **106,477,016.77** | **210,928,179.38** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 106,477,016.77 | 210,928,179.38 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 98,985,450.00 | 98,985,450.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 98,985,450.00 | 98,985,450.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 7,270,863.77 | 111,938,392.38 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 7,270,863.77 | 7,487,229.77 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 104,451,162.61 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 220,703.00 | 4,337.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **106,477,016.77** | **217,623,179.38** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,341,647,700.00** | **2,299,195,272.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **7,587,790.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 7,587,790.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 00.00 | 900,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 00.00 | 900,000.00 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 6,687,790.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,341,647,700.00** | **2,291,607,482.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,300,550,200.00 | 1,994,690,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,300,550,200.00 | 1,994,690,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 41,097,500.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 41,097,500.00 | 00.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 00.00 | 296,917,282.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 00.00 | 296,917,282.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,391,162,187.82** | **2,194,237,367.62** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,391,162,187.82** | **2,194,237,367.62** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,326,499,093.34 | 2,057,236,893.46 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 490,755,483.80 | 581,514,760.22 |
| 210101 | Үндсэн цалин | 271,344,343.28 | 322,091,942.26 |
| 210102 | Нэмэгдэл | 160,506,592.52 | 189,738,874.96 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 43,828,000.00 | 45,486,000.00 |
| 210104 | Урамшуулал | 15,076,548.00 | 24,197,943.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 61,519,000.04 | 73,334,832.31 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 41,838,867.23 | 49,899,994.64 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,969,533.20 | 5,870,587.58 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,451,766.62 | 2,927,377.43 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,451,766.62 | 2,927,377.43 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,807,066.37 | 11,709,495.23 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 81,249,338.18 | 48,480,800.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,714,450.00 | 4,143,450.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 69,464,200.00 | 37,592,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,385,668.18 | 3,747,050.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,685,020.00 | 2,997,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 27,784,500.00 | 119,977,457.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 185,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 27,784,500.00 | 119,792,457.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 20,025,400.00 | 13,410,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 20,025,400.00 | 13,410,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 469,365,372.50 | 906,850,202.31 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 465,844,440.50 | 903,999,970.31 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 1,080,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 978,400.00 | 1,641,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 90,532.00 | 129,232.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,430,000.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 175,799,998.82 | 313,668,841.62 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 91,792,550.00 | 180,967,146.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 30,011,000.00 | 69,863,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 53,454,920.27 | 61,242,195.62 |
| 210904 | Найдваргүй авлагын алдагдал | 541,528.55 | 1,596,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 64,663,094.48 | 137,000,474.16 |

| | | | |
|---|---|---|---|
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 16,979,633.98 | 120,856,474.16 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 16,979,633.98 | 120,856,474.16 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 47,683,460.50 | 16,144,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 5,742,000.00 | 3,250,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 41,941,460.50 | 12,894,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-49,514,487.82** | **104,957,904.38** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 47,124,999.56 | 506,741.77 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 47,124,999.56 | 506,741.77 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -47,124,999.56 | -506,741.77 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-96,639,487.38** | **104,451,162.61** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,341,647,700.00** | **2,298,295,272.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **6,687,790.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 6,687,790.00 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 6,687,790.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,341,647,700.00** | **2,291,607,482.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,300,550,200.00 | 1,994,690,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,300,550,200.00 | 1,994,690,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 41,097,500.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 41,097,500.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 296,917,282.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 00.00 | 296,917,282.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,334,709,139.00** | **2,126,887,172.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,334,709,139.00** | **2,126,887,172.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,270,046,044.52** | **1,990,086,697.84** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 490,755,483.84 | 581,514,760.22 |
| 210101 | Үндсэн цалин | 272,523,061.99 | 322,091,942.26 |
| 210102 | Нэмэгдэл | 159,357,328.40 | 189,738,874.96 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 43,798,545.45 | 45,486,000.00 |
| 210104 | Урамшуулал | 15,076,548.00 | 24,197,943.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 61,519,000.00 | 73,334,832.31 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 41,838,867.19 | 49,899,994.64 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,969,533.20 | 5,870,587.58 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,451,766.62 | 2,927,377.43 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,451,766.62 | 2,927,377.43 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,807,066.37 | 11,709,495.23 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 77,181,338.18 | 49,728,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 3,274,450.00 | 3,771,650.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 65,464,200.00 | 37,394,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,385,668.18 | 4,316,850.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,057,020.00 | 4,245,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 25,604,500.00 | 120,901,457.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 1,109,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 25,604,500.00 | 119,792,457.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 20,217,400.00 | 13,410,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 20,217,400.00 | 13,410,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 473,173,372.50 | 901,500,302.31 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 469,652,440.50 | 899,730,070.31 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 978,400.00 | 1,641,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 90,532.00 | 129,232.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,430,000.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 121,594,950.00 | 249,696,546.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 91,594,950.00 | 181,370,886.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 30,000,000.00 | 68,325,660.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **64,663,094.48** | **136,800,474.16** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 16,979,633.98 | 120,856,474.16 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 16,979,633.98 | 120,856,474.16 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 47,683,460.50 | 15,944,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 5,742,000.00 | 3,050,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 41,941,460.50 | 12,894,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **6,938,561.00** | **171,408,100.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **6,938,561.00** | **171,408,100.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **6,938,561.00** | **171,408,100.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 6,938,561.00 | 171,408,100.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 6,938,561.00 | 171,408,100.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-6,938,561.00** | **-171,408,100.00** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| С01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 98,985,450.00 | 8,419,234.64 | -33,818,159.95 | 73,586,524.69 |
| С02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 48,720.00 | 48,720.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **98,985,450.00** | **8,419,234.64** | **-33,769,439.95** | 73,635,244.69 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 29,077,639.87 | 29,077,639.87 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **98,985,450.00** | **220,703.00** | **7,270,863.77** | 106,477,016.77 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **98,985,450.00** | **220,703.00** | **7,270,863.77** | 106,477,016.77 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 216,366.00 | 216,366.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **98,985,450.00** | **220,703.00** | **7,487,229.77** | 106,693,382.77 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -216,366.00 | 00.00 | -216,366.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 104,451,162.61 | 104,451,162.61 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **98,985,450.00** | **4,337.00** | **111,938,392.38** | 210,928,179.38 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 3,048,214,400.00 | 1,874,118,725.84 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 3,048,214,400.00 | 1,874,118,725.84 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 3,009,910,400.00 | 1,858,174,725.84 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 582,169,600.00 | 581,514,760.22 |
| 210101 | Үндсэн цалин | 283,092,700.00 | 322,091,942.26 |
| 210102 | Нэмэгдэл | 202,290,400.00 | 189,738,874.96 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 55,440,000.00 | 45,486,000.00 |
| 210104 | Урамшуулал | 41,346,500.00 | 24,197,943.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 73,334,900.00 | 73,334,832.31 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 49,867,700.00 | 49,899,994.64 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,866,800.00 | 5,870,587.58 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,933,400.00 | 2,927,377.43 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,933,400.00 | 2,927,377.43 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,733,600.00 | 11,709,495.23 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 49,728,800.00 | 49,728,800.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,624,300.00 | 3,771,650.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 37,920,000.00 | 37,394,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,939,000.00 | 4,316,850.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,245,500.00 | 4,245,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 79,511,100.00 | 79,502,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 57,500,000.00 | 9,528,900.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 44,698,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 22,011,100.00 | 25,275,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 13,445,600.00 | 13,410,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 13,445,600.00 | 13,410,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,891,013,600.00 | 857,982,487.31 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,889,243,200.00 | 856,212,255.31 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,641,000.00 | 1,641,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 129,300.00 | 129,232.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 100.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 320706800.00 | 202701546.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 302,376,000.00 | 184,370,886.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 18,330,800.00 | 18,330,660.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 38304000.00 | 15944000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 38,304,000.00 | 15,944,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 8,050,100.00 | 3,050,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 26,056,800.00 | 12,894,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,197,100.00 | 00.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 3,048,214,700.00 | 1,994,690,200.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 3,048,214,700.00 | 1,994,690,200.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 3,048,214,700.00 | 1,994,690,200.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

### НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **303,320,072.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **303,320,072.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **303,320,072.00** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 208,557,357.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 114,040,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 94,517,357.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 44,767,715.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 44,767,715.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 49,995,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 49,995,000.00 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 296,917,282.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 296,917,282.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 296,917,282.00 |

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 20,631.1 мянган төгрөгийн алдаа[1] илэрснийг аудитын явцад залруулсан байна. Үүнд:

- ✓ Тайлангийн уялдааг тулгахад санхүүгийн тайлан зөрүүтэй илэрхийлсэн алдааг аудитаар залрууллаа.

Аудитаар нийт 752,611.2 мянган төгрөгийн зөрчил илэрсний 2,000.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 636,571.2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 114,040.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

**5.1 Төлбөрийн акт**

Өмнөх аудитаар илэрсэн зөвлөх чиг үүрэг бүхий албан тушаалд иргэнийг томилож цалин олгосон зөрчлийг давтан гаргаж 2,000.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

**5.2 Албан шаардлага**

- Тус байгууллагын батлагдсан төсвөөс Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын захирамжид үндэслэн 844,540.0 мянган төгрөгийг зарцуулснаас аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлд тусгагдсан 216,660.2 мянган төгрөгийг үр ашиггүй үрэлгэн, зориулалт бус зарцуулсан,
- Улс төрийн намуудад 108,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 9,000.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн,
- Улс, аймгийн аварга малчин, аймгийн сайн малчин, алтан төлийн эздэд аймгийн Засаг даргын нөөц сангаас бэлэг дурсгалын зардал гаргасан байхад тус байгууллагын төсвөөс давхар зардал гаргаж 4,600.0 мянган төгрөгийн төсвийг үр ашиггүй зарцуулсан,
- Аймгийн ИТХ-ын төлөөлөгч нарын үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээнд 444,396.1 мянган төгрөг зарцуулсан нь Засгийн газрын тогтоолоор баталсан жишиг хэмжээнээс хэтэрсэн бөгөөд үүний 175,000.0 мянган төгрөгийг тойрогтоо ажиллах үйл ажиллагааны зардалд 190,560.0 мянган төгрөгийг гадаад улсын туршлага судлахад, 78,836.1 мянган төгрөгийг дотоод туршлага судлах арга хэмжээнд зарцуулсан байна. Ингэхдээ гадаад улсад туршлга судлах ажлыг сургалтын чиглэлээр мэргэшсэн байгууллагатай хамтран зохион байгуулаагүй, аялалын компаниудтай хамтран хэрэгжүүлсэн, туршлага судлах арга хэмжээний зардлыг сургалтын үйл ажиллагаанаас өөр чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийн дансанд байршуулж, зарцуулснаар тайлагнасан 269,400.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн,
- Аливаа хуулийн этгээдээр ажил гүйцэтгүүлэхдээ үйл ажиллагааны чиглэлийг харгалзан үзэлгүй шууд гэрээ байгуулан 11,100.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон,

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлын албаны бүтэц, орон тоо, ажиллах журмыг холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрээр батлаагүй мөртлөө хоёр ажилтанг төрийн үйлчилгээний албан тушаалд томилж 14,139.8 мянган төгрөгийн цалин олгосон,
- Албан хаагчдад үр дүнгийн урамшууллаас гадна 1,621.2 мянган төгрөгийн нэмэлт шагнал, урамшуулал олгосон,
- Спорт заалны түрээс болон фитнесийн сургалтын төлбөрт 2,050.0 мянган төгрөг төлсөн зэрэг байна.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Төсвийн зарцуулалттай холбоотой**

1.1 Илрүүлэлт: Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр ИТХ-ын төлөөлөгч нарт тоног төхөөрөмж /таблет/ худалдан авч, төлөөлөгч бүрд тараан өгсөн байна. Энэ нь хөрөнгө эзэнгүйдэх, үрэгдэх эрсдэлийг бий болгосон, оршин байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тоног төхөөрөмжийг хөрөнгийн ашиглалтын картаар эзэмшүүлэн, ашиглалт, хамгаалалтад байнгын хяналт тавьж байх;

Энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу гарган зөвлөмж хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлж, биелэлтийг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэн 2026 оны 06 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

## Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнэээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайланг зөрүүтэй илэрхийлсэн | 1 | 20,631.1 | | | 1 | 20,631.1 | 1 | 20,631.1 | | | | |
| **ДҮН** | **1** | **20,631.1** | | | **1** | **20,631.1** | **1** | **20,631.1** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тоо | Дүн | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн |
| Тус байгууллагын батлагдсан төсвөөс Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын захирамжид үндэслэн 844,540.0 мянган төгрөгийг зарцуулснаас аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлд тусгагдсан 216,660.2 мянган төгрөгийг үр ашиггүй үрэлгэн, зориулалт бус зарцуулсан | 1 | 216,660.2 | | | 1 | 216,660.2 | | | | | | |
| Улс төрийн намуудад санхүүжилт олгож, дэмжлэг үзүүлсэн | 1 | 117,000.0 | | | 1 | 117,000.0 | | | | | | |
| Аймгийн ИТХ-ын төлөөлөгч нарын үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээнд 444,396.1 мянган төгрөг зарцуулсан нь Засгийн газрын тогтоолоор баталсан жишиг хэмжээнээс хэтэрсэн бөгөөд үүний 175,000.0 мянган төгрөгийг тойрогтоо ажиллах үйл ажиллагааны зардалд 190,560.0 мянган төгрөгийг гадаад улсын туршлага судлахад, 78,836.1 мянган төгрөгийг дотоод туршлага судлах арга хэмжээнд зарцуулсан байна. Ингэхдээ гадаад улсад туршлга судлах ажлыг сургалтын чиглэлээр мэргэшсэн байгууллагатай хамтран зохион байгуулаагүй, аялалын компаниудтай хамтран хэрэгжүүлсэн, туршлага судлах арга хэмжээний зардлыг сургалтын үйл ажиллагаанаас өөр чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийн дансанд байршуулж, зарцуулснаар тайлагнасан | 1 | 269,400.0 | | | 1 | 269,400.0 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Аливаа хуулийн этгээдээр ажил гүйцэтгүүлэхдээ үйл ажиллагааны чиглэлийг харгалзан үзэлгүй шууд гэрээ байгуулан санхүүжилтийг олгосон | 1 | 11,100.0 | | | 1 | 11,100.0 | | | | | | |
| Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлын албаны бүтэц, орон тоо, ажиллах журмыг холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрээр батлаагүй мөртлөө хоёр ажилтанг төрийн үйлчилгээний албан тушаалд томилж цалин олгосон | 1 | 14,139.8 | | | 1 | 14,139.8 | | | | | | |
| Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр ИТХ-ын төлөөлөгч нарт тоног төхөөрөмж /таблет/ худалдан авч, төлөөлөгч бүрд тараан өгсөн байна. Энэ нь хөрөнгө эзэнгүйдэх, үрэгдэх эрсдэлийг бий болгосон, оршин байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. | 1 | 114,040.0 | | | | | 1 | 114,040.0 | | | | |
| **ДҮН** | **6** | **742,340.0** | | | **5** | **628,300.0** | **1** | **114,040.0** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Өмнөх аудитаар илэрсэн зөвлөх чиг үүрэг бүхий албан тушаалд иргэнийг томилж цалин олгосон зөрчлийг давтан гаргаж урамшуулал олгосон | 1 | 2,000.0 | 1 | 2,000.0 | | | | |
| Улс, аймгийн аварга малчин, аймгийн сайн малчин, алтан төлийн эздэд аймгийн Засаг даргын нөөц сангаас бэлэг дурсгалын зардал гаргасан байхад тус байгууллагын төсвөөс давхар зардал гаргаж 4,600.0 мянган төгрөгийн төсвийг үр ашиггүй зарцуулсан | 1 | 4,600.0 | | | 1 | 4,600.0 | | |
| Албан хаагчдад үр дүнгийн урамшууллаас гадна нэмэлт шагнал, урамшуулал олгосон, спорт заалны түрээс болон фитнесийн сургалтын төлбөрт төлсөн | 1 | 3,671.2 | | | 1 | 3,671.2 | | |
| Дүн | 3 | 10,271.2 | 1 | 2,000.0 | 2 | 8,271.2 | | |
| **Нийт дүн** | **3** | **10,271.2** | **1** | **2,000.0** | **2** | **8,271.2** | | |

### Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | Санал дүгнэлтийн хэлбэр |
|---|---|---|---|

|  |  |  | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр |  |  |  |  |  |  |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
|  |  | Аудитад хамрагдах | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт гаргахаас татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 |  |  |  | 1 |  |  |
|  | НИЙТ | 1 | 1 |  |  |  | 1 |  |  |

ХЯНАСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-ҮНДРАА 2026.02.27

АУДИТЫН МЕНЕЖЕР Х.БОЛДБААТАР 2026.02.27

БОЛОВСРУУЛСАН : АХЛАХ АУДИТОР Б.ЖАЛБАА 2026.02.27